



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ЗҮҮНБАЯН ТӨМӨР ЗАМ” ХХК 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД  
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/73/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор  
Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер: Д.Энхдалай  
Утас: 261885 Цахим хаяг: [enkhdalaid@audit.gov.mn](mailto:enkhdalaid@audit.gov.mn)  
Ахлах аудитор: Б.Эрдэнэзул  
Утас: 261740 Цахим хаяг: [erdenezulb@audit.gov.mn](mailto:erdenezulb@audit.gov.mn)  
Гэрээгээр гүйцэтгэсэн “Гроут Финанс Аудит” ХХК-ийн  
Захирал Б.Бямба  
Утас: 99094391 Цахим хаяг: [byambaa@growthfinance.mn](mailto:byambaa@growthfinance.mn)

Улаанбаатар хот  
2022 он

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт .....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан .....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	8
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Дотоод хяналт .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Материаллаг байдал .....	11
4. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
4.1 Байгууллагын үйл ажилагаа .....	11
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин,.....	12
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого .....	13
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
5.1 Шилэн дансны мэдээлэл .....	14
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
8. Аудитын илрүүлэлт .....	16
8.1 Залруулсан алдаа.....	16
8.4 Зөвлөмж .....	16
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	18
10. Хавсралт: Албан шаардлага .....	19

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ЭТТ ХК	Эрдэнэс тавантолгой ХК



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2022.03.15 № 07/625  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ЗҮҮНБАЯН ТӨМӨР ЗАМ ХХК-  
ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Д.БАНЗРАГЧ ТАНАА

### Хараат бус аудиторын тайлан

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн нөлөөг эс тооцвол “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 294.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан дангаараа эсвэл нийтдээ материаллаг боловч өргөн тархаагүй, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.1 “үнийн санал ирүүлэх урилгыг энэ хуулийн 52.1.12, 53.5.4-т заасан худалдан авах ажиллагааны цахим системд зарлаж, үр дүнг тухай бүр мэдээлэх”, 33.2.2 “техникийн болон бусад нөхцөл шаардлагыг хангаж байгаа хамгийн бага үнэ санал болгосон төндэрт оролцогчид энэ хуулийн 29.1-д заасны дагуу гэрээ байгуулах эрх олгох” 8 дугаар зүйлийн 8.1.2. “шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар;”, “Санхүүжилтийн гэрээ” 3 дугаар зүйлийн 3.1 “Зүүнбаян төмөр зам ХХК нь дараах нөхцөл хангагдсаны дараа энэхүү гэрээнд заасан санхүүжилтийг Монголын төмөр зам ТӨХК-ийн дансанд шилжүүлнэ”, 3.1.2-т “Энэхүү гэрээнд заасан үнийн дүн бүхий санхүүжилтийг Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын суурь бүтэц барих шаардлагатай санхүүжилтийн баталгаажсан гүйцэтгэлийн дүнгээс шилжүүлэх төлбөрийн задаргааг /ажил, гэрээ тус бүрээр;/ Монголын төмөр зам” ТӨХК-аас ирүүлсэн; 4.2. “Энэхүү гэрээний дагуу хүлээн авсан санхүүжилтийг талуудын хянан баталгаажсан актад заасан дүнгээр төмөр замын төслийн гүйцэтгэлд зориулна” заалт гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх батламж

мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцолсон зүйл**

Монгол Улсын Засгийн Газрын 117 дугаар тогтоолын 2-т “Монголын төмөр зам” ТӨХК-д олгосон Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын суурь бүтэц барих зөвшөөрлийг цуцалж “Зүүнбаян төмөр зам” ХХК-д 2020 оны 09 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн 3 жилийн хугацаатай олгох шийдвэрийн дагуу Зам, тээврийн хөгжлийн яамнаас “Зүүнбаян төмөр зам” ХХК-д тусгай зөвшөөрлийг олгосон. Гэвч Зам, тээврийн хөгжлийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд нарын 2020 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 1 дүгээр хурлын тэмдэглэлээр Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн барилгын ажил дуусах хүртэл хугацаанд төслийн ерөнхий захиалагч “Монголын төмөр зам” ТӨХК хариуцан ажиллаж Улсын комисст хүлээлгэн өгсний дараа хөндлөнгийн аудит хийлгэж, “Зүүнбаян төмөр зам” ХХК-д шилжүүлэх”-ээр шийдвэрлэсэн байна.

Төмөр замын суурь бүтцийг 2022 онд хүлээн авахтай холбогдуулан компанийн дүрэм болон холбогдох баримт бичигт заасан үйл ажиллагааг эрхлэхтэй холбогдуулан Зам тээвэр хөгжлийн яамнаас “Төмөр замын суурь бүтэц ашиглах тусгай зөвшөөрөл”, “Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл”, Төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн үйлдвэрлэх угсрах, засварлах тусгай зөвшөөрөл”-ийг холбогдох байгууллагуудаас авахаар төлөвлөгөөнд тусгасан байна.

### **Аудитын гол асуудлууд**

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Тайлант онд “Зүүнбаян төмөр зам” ХХК нь “Эрдэнэс-Тавантолгой” ХК-тай байгуулсан “Хөрөнгө оруулалт санхүүжилт”-ын гэрээний дагуу нийт 270.4 тэрбум төгрөг хүлээн авч “Монголын төмөр зам” ТӨХК-д гэрээний дагуу шилжүүлсэн. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг хүлээн авахтай холбогдуулан гарах үйл ажиллагааны зардлыг ТУЗ-ийн 09 тоот тогтоолд 3,671.5 сая төгрөг байхаар баталж, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-тай байгуулсан санхүүжилтийн гэрээнд зааснаар уг зардлыг хөрөнгө оруулалтаар тооцохоор шийдвэрлэсний дагуу гүйцэтгэлээр гарсан 2,666.6 сая төгрөгийн зардлыг капиталжуулсан.

Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6.1 дэх хэсэгт заасны дагуу 2021 оны үйл ажиллагаанд шаардлагатай бараа, ажил, үйлчилгээний 29 худалдан авах ажиллагаанд 1,250.9 сая төгрөг төлөвлөснөөс 10 төрлийн бараа, ажил, үйлчилгээнд 643.2 сая төгрөг зарцуулсан байна.

### **Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Компани тайлант хугацаанд үйл ажиллагааны батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан 5-н зорилтын хүрээнд 47 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 99.1 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн бүтээн байгуулалтын ажил тайлант оны эцсээр 95.0 хувь, санхүүжилт 85.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

*В. Р. Ц*

Ц НАРАНЧИМЭГ



## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
			/төгрөгөөр/
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	50,469,070.00	299,805,312.41
1.1.2	Дансны авлага	-	-
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	-	608,364.59
1.1.4	Бусад авлага	3,894,550.00	154,690.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	-	91,305,201.80
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	74,953,894,550.00	347,706,150,326.57
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.1.11	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>75,008,258,170.00</b>	<b>348,098,023,895.37</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,001,000.00	312,740,545.88
1.2.2	Биет бус хөрөнгө	-	25,993,719.64
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
1.2.10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>1,001,000.00</b>	<b>338,734,265.52</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>75,009,259,170.00</b>	<b>348,436,758,160.89</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
2.1.1	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	-	-
2.1.1.2	Цалингийн өглөг	9,360,786.27	-
2.1.1.3	Татварын өр	1,000,087.36	41,774.69
2.1.1.4	НДШ-ийн өр	2,881,034.55	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	-
2.1.1.6	Хүүгийн өглөг	-	-
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	-	-
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	17,219,389.00
2.1.1.13	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>13,241,908.18</b>	<b>17,261,163.69</b>
2.1.2	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	-	-
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.6	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>		
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>13,241,908.18</b>	<b>17,261,163.69</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч:-төрийн	10,000,000.00	10,000,000.00
2.3.2	хувийн		
2.3.3	хувьцаат		
2.3.8	Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг	75,000,000,000.00	348,405,361,884.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(13,982,738.18)	4,135,113.20
2.3.11	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>74,996,017,261.82</b>	<b>348,419,496,997.20</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>75,009,259,170.00</b>	<b>348,436,758,160.89</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>		
2	Борлуулалтын өртөг		
3	<b>Нийт ашиг( алдагдал)</b>		
4	Бусад орлого		4,177,468.69
5	Борлуулалт, маркетингийн зардал	738,990.00	-
6	Ерөнхий ба удирдлагын зардал	13,243,748.19	
8	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		(580.81)
9	Бусад ашиг ( алдагдал)		
10	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)</b>	<b>(13,982,738.19)</b>	<b>4,176,887.88</b>
11	Орлогын татварын зардал		<b>41,774.69</b>
12	Тайлангийн үеийн орлогын татварын зардал		41,774.69
13	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(13,982,738.19)</b>	<b>4,135,113.19</b>
14	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>		
15	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>(13,982,738.19)</b>	<b>4,135,113.19</b>
16	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>		
17	<b>Орлогын нийт дүн</b>	<b>(13,982,738.19)</b>	<b>4,135,113.19</b>
18	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>	-	-

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2020 оны 01 -р сарын 01-ний үлдэгдэл</b>	10,000,000.00			10,000,000.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		75,000,000,000.00		75,000,000,000.00
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>10,000,000.00</b>	<b>75,000,000,000.00</b>		<b>75,010,000,000.00</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(13,982,738.18)	(13,982,738.18)
<b>2021 оны 01-р сарын 01-ээрх үлдэгдэл</b>	<b>10,000,000.00</b>	<b>75,000,000,000.00</b>	<b>(13,982,738.18)</b>	<b>74,996,017,261.82</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			13,982,738.18	13,982,738.18
Өмчид гарсан өөрчлөлт		273,405,361,884.00		273,405,361,884.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			4,135,113.19	4,135,113.19
<b>2021 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл</b>	<b>10,000,000.00</b>	<b>348,405,361,884.00</b>	<b>4,135,113.19</b>	<b>348,419,496,997.20</b>

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	-	<b>5,003,236.00</b>
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	3,946,003.00
	Бусад мөнгөн орлого	-	1,057,233.00
1.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>74,958,529,930.00</b>	<b>272,803,199,786.16</b>
	Ажиллагчдад төлсөн	-	1,226,605,701.65
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	-	390,385,815.18
	Бараа материал худалдан авахад төлсөн	-	143,026,308.50
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-	14,199,000.00
	Татварын байгууллагад төлсөн	-	130,313,389.86
	Бусад мөнгөн зарлага	74,958,529,930.00	270,898,669,570.97
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(74,958,529,930.00)</b>	<b>(272,798,196,550.16)</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	-	<b>22,762,308.38</b>
	Хүлээн авсан хүүгийн орлого		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгааны буцаан төлөлт	-	22,762,308.38
2.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>1,001,000.00</b>	<b>380,590,819.00</b>
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,001,000.00	354,375,319.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	26,215,500.00
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(1,001,000.00)</b>	<b>(357,828,510.62)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
3.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>75,000,000,000.00</b>	<b>273,405,361,907.19</b>
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	75,000,000,000.00	273,405,361,884.00
	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	-	23.16
3.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>		<b>603.97</b>
	Валютын ханшийн зөрүү		603.97
3.3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>75,000,000,000.00</b>	<b>273,405,361,303.19</b>
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>40,469,070.00</b>	<b>249,336,242.41</b>
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>10,000,000.00</b>	<b>50,469,070.00</b>
6	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>50,469,070.00</b>	<b>299,805,312.41</b>



## 2.5 Зардлын төсөв, гүйцэтгэл

№	Үзүүлэлт	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1</b>	<b>Хөрөнгө оруулалт</b>		<b>396,172,000</b>	<b>401,052,900</b>	<b>4.880,900</b>	<b>101.2</b>
1.1	Компьютер, түүний дагалдах хэрэгсэл		191,200,000	187,685,700	(3,514,300)	98.2
1.2	Программ хангамж /MS Office 365/		21,150,000	21,215,500	65,500	100.3
1.3	Хурлын өрөөний тоног төхөөрөмж		9,000,000	8,994,400	(5,600)	99.9
1.4	Нууцын материал хадгалах бүрдэл		9,000,000	8,900,000	(100,000)	98.9
1.5	Камер /хэвлэл мэдээлэл/		9,900,000	9,900,000	-	100.0
1.6	Ухаалаг дэлгэц		9,850,000	9,765,000	(85,000)	99.1
1.7	Хяналтын камер		1,500,000	1,474,800	(25,200)	98.3
1.7	Тавилга эд хогшил		74,852,000	74,826,900	(25,100)	100.0
1.9	Бусад үндсэн хөрөнгө		9,720,000	9,640,600	(79,400)	99.2
1.10	Тээврийн хэрэгсэл /12 хүний суудалтай автомашин/		60,000,000	58,800,000	(1,200,000)	98.0
1.11	Тусгай зөвшөөрөл		-	5,000,000	5,000,000	100.0
1.12	Брендинг		-	4,850,000	4,850,000	100.0
<b>2</b>	<b>Үйл ажиллагааны зардал</b>		<b>3,275,331,000</b>	<b>2,265,564,360</b>	<b>(1,009,766,640)</b>	<b>69.2</b>
2.1	Цалингийн хөлс, НДШ	13,243,748	2,253,558,000	1,688,313,200	(565,244,800)	74.9
2.2	Интернет үйлчилгээний төлбөр		8,400,000	3,848,100	(4,551,900)	45.8
2.3	Утас, харилцаа холбооны төлбөр		5,060,000	3,126,300	(1,933,700)	61.8
2.4	Оффисын түрээс, ашиглалт		161,305,000	120,766,300	(40,538,700)	74.9
2.4	Бичиг хэргийн зардал		17,064,000	8,490,750	(8,573,250)	49.8
2.6	Цай кофе, бусад материал		8,800,000	5,019,500	(3,780,500)	57.0
2.7	Цэвэрлэгээний материал		7,320,000	2,545,300	(4,774,700)	34.8
2.8	Хэвлэл мэдээлэл, арга хэмжээ		104,000,000	49,809,090	(54,190,910)	47.9
2.9	Мэргэшүүлэх, мэдлэг олгох сургалт		32,000,000	6,546,200	(25,453,800)	20.5
2.10	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны сургалт		8,640,000	7,650,000	(990,000)	88.5
2.11	Стандартын сургалт		17,500,000	6,300,000	(11,200,000)	36.0
2.12	Эрүүл мэндийн хөтөлбөр		5,500,000	2,573,000	(2,927,000)	46.8
2.13	Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл		67,500,000	2,697,500	(64,802,500)	4.0
2.14	Эрүүл мэндийн үзлэг, оношилгоо		21,600,000	20,238,000	(1,362,000)	93.7
2.15	Ковидын эсрэг халдвар хамгаалал		17,280,000	8,942,900	(8,337,100)	51.8
2.16	Автомашин түрээс		117,520,000	10,913,500	(106,606,500)	9.3
2.17	Засвар үйлчилгээ /автомашин/		10,764,000	3,583,500	(7,180,500)	33.3
2.18	Шатахууны зардал		71,160,000	35,310,800	(35,849,200)	49.6

2.19	Томилолтын зардал		30,400,000	26,102,000	(4,298,000)	85.9
2.20	Аудит		28,560,000	28,040,000	(520,000)	98.2
2.21	Зөвлөх үйлчилгээ		113,400,000	71,992,700	(41,407,300)	63.5
2.22	Оффис засвар		28,000,000	22,151,500	(5,848,500)	79.1
2.23	Компанийн вэб сайт хийлгэх		7,000,000	6,468,000	(532,000)	92.4
2.24	Брэнд бүүк хийлгэх		7,000,000	-	(7,000,000)	0.0
2.25	ISO стандарт нэвтрүүлэх		18,000,000	17,600,000	(400,000)	97.8
2.26	Бусад зардал	738,990	108,000,000	43,217,200	(64,782,800)	40.0
2.27	Элэгдлийн зардал		-	63,319,600	63,319,600	100.0
2.28	Ханшийн зөрүү		-	(580)	(580)	
	<b>Нийт төсөв</b>	<b>13,982,738</b>	<b>3,671,503,000</b>	<b>2,666,617,260</b>	<b>(1,004,885,740)</b>	<b>72.6</b>

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад төмөр замын бүтээн байгуулалтын төслийн санхүүжилтийн гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах, хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 20-наас 2022 оны 03 дугаар сарын 13-ны хооронд “Гроут Финанс Аудит” ХХК-ийн захирал Б.Бямба, аудитор Ү.Цэцэгмаа, туслах аудитор Т.Гантуул, А.Амаржаргал нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер Ч.Хүнбиш чанарын хяналтыг хэрэгжүүлсэн.

“Зүүнбаян төмөр зам” ХХК 2021 оны санхүүгийн тайланг “Гроут Финанс Аудит” ХХК-д 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 01/19 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компани нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан, ТУЗ-д танилцуулан, батлуулах шатандаа явж байна.

“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Дотоод аудитын албаны 2021 оны төлөвлөгөө, ТУЗ-ийн баталсан ЗБТЗ-ДАА/ГА-2021/01 дугаар удирдамжийн дагуу “Зүүнбаян төмөр зам” ХХК-д оруулсан төслийн санхүүжилт, зарцуулалт, үйл ажиллагаа, хүний нөөц, дотоод бичиг баримтын хүрээг хамруулан хяналт шалгалт хийж, 8 зөвлөмж өгч ажилласан байна.

“Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн дотоод хяналтын алба нь компанийн дотоод хяналт шалгалтыг холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд зохион байгуулж, компанийн үйл ажиллагаанд гарч буй дутагдал, доголдол, тулгамдаж буй асуудлыг олж тогтоох, тэдгээрийн шалтгааныг олж илрүүлэн, хууль тогтоомж, стандартад нийцүүлэх, оновчтой шийдвэр гаргаж, зөв чиглэлд оруулах үүрэгтэйгээр ажиллаж байна.

Компанийн үйл ажиллагааг жигдрүүлэх, компанийн үндсэн үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангах зорилтын хүрээнд Гүйцэтгэх захирлын 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/14 тоот тушаалаар 12 төрлийн 24 хяналт шалгалтыг хийж гүйцэтгэхээр баталж, хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

“Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан үйл ажиллагааны нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл өндөр гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан үйл ажиллагааны зардлын 3,671.5 сая төгрөгөөс 0.5 хувиар буюу 18.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## 4. Санхүүгийн тайлангийн тодруулга

### 4.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн эрхэм зорилго нь төмөр замын олон улсын жишиг үйлчилгээ үзүүлэгч байхад оршино.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төмөр замын суурь бүтцийг барих, ашиглах замаар төмөр замын дотоодын тээвэр, ложистикийн сүлжээг өргөжүүлэх, ,
- Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд, боловсруулах үйлдвэрийн ачаа тээвэрлэлтийн эргэлтийг нэмэгдүүлэх,
- Дэд бүтцийг дагасан хот, суурин газар бий болгох,
- Хүрээлэн буй орчинд үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг бууруулж, үндэсний эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулах
- Хувьцаа эзэмшигчдийнхээ хөрөнгийн өгөөжийг өсгөхөд чиглэнэ.

“Төрийн өмчит хуулийн этгээд байгуулах, зөвшөөрөл олгох, төмөр замын барилгын ажлын санхүүжилтийг шийдвэрлэх арга хэмжээний тухай” Монгол улсын Засгийн газрын 2020 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 117 дугаар тогтоол, “Монголын төмөр зам” ТӨХК болон “Эрдэнэс-Тавантолгой” ХК-уудын 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн “Хувьцаа эзэмшигчдийн гэрээ”-ний дагуу Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барих, нийт 416.2 км төмөр замын суурь бүтцийг эзэмших, ашиглах зорилгоор “Зүүнбаян төмөр зам” ХХК байгуулагдсан байна

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Хязгаарлагдмал хариуцлагатай компани статустай байна. Компанийн эргэлтэд гаргасан энгийн хувьцааны 66 хувийг “Эрдэнэс-Тавантолгой” ХК, 34 хувийг “Монголын төмөр зам” ТӨХК эзэмшиж байна.

Дотоод зохион байгуулалтын бүтцийг ТУЗ-ийн 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 09 тоот тогтоолоор орон тоог 48, ТУЗ-ийн 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 03 тоот тогтоолоор ТУЗ-ийн дэргэд дотоод аудитын алба байгуулан орон тоог 3-аар нэмэгдүүлэн 51 болгосон. Мөн ТУЗ-ийн 2021 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 10 тоот тогтоолоор дохиолол төвлөрүүлэлт, хориглолтын системийн ажлын захиалагчийн хяналт хийхтэй холбоотой төмөр замын дохиолол холбооны чиглэлийн 5 инженерийн орон тоог бий болгон орон тооны дээд хязгаарыг 56 болгон өөрчлөлт оруулсан байна

#### **4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин,**

“Зүүнбаян төмөр зам” ХХК-ийг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн 117 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах...” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлагыг ТУЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 06 тоот тогтоолоор, ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 03 тоот тогтоолоор томилсон байна.

“Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг 0.84 сая төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалттай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна.

Энэ хүрээнд 2021 оны 03 дугаар сарын 31-ны өдрийн Өмч хамгаалах байнгын зөвлөл байгуулж, А/135 дугаар тушаалаар “Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журам” батлуулан мөрдөж ажиллаж байна. Гүйцэтгэх захирлын А/71 дугаар тушаал, А/142 дугаар тушаалаар тооллогын комисс байгуулж хөрөнгийн тооллогыг 2 удаа хийсэн. Эд хариуцагч нартай эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ байгуулж өмч хамгаалах байнгын зөвлөлөөр эд хөрөнгийн ашиглалтын үйл ажиллагааг хянуулсан. Үндсэн хөрөнгүүдийн хадгалалт хамгаалалт, бүрэн бүтэн байдлын хангах, хөрөнгийн хариуцлагыг дээшлүүлэх, хөрөнгүүдийг коджуулан хөрөнгө, эзэмшигч нарт карт хөтлөн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Засгийн Газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- Засгийн Газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;

### 4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

“Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	50,469.0	299,805.3	249,336.3
Авлага	3,894.5	763.0	(3,131.5)
Урьдчилгаа	74,953,894.5	347,706,150.3	272,752,255.8
Бараа материал	-	91,305.2	91,305.2
Үндсэн хөрөнгө	1,001.0	312,740.5	311,739.5
Биет бус хөрөнгө		25,993.7	25,993.7
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>75,009,259.1</b>	<b>348,436,758.1</b>	<b>273,427,499.0</b>
Өр төлбөрийн дүн	<b>13,241.9</b>	<b>17,261.2</b>	<b>4.0</b>
Богино хугацаат өглөг	13,241.9	17,261.2	4.0
Эздийн өмч	10,000.0	10,000.0	-
Эздийн өмчийн бусад хэсэг	75,000,000.0	348,405,361.8	273,405,361.8
Хуримтлагдсан ашиг	(13,982.7)	4,135.1	(9,847.6)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>75,009,259.1</b>	<b>348,436,758.1</b>	<b>273,427,499.0</b>

/мянган төгрөг/

Өмнөх оны үзүүлэлтүүдээс дараах дансуудын үлдэгдэлд материаллаг дүнтэй өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 299.8 сая төгрөг болж 249,336.3 сая төгрөгөөр өссөн нь санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээ буюу өмчийн хэрэглүүрээс тайлант онд зарцуулаагүй үлдэгдэл байнаас шалтгаалжээ. Үүнээс касс дахь бэлэн мөнгөний эцсийн үлдэгдэл 4.0 сая төгрөг, банк дахь харилцах дансанд 295.8 сая төгрөг;
- Авлагын үлдэгдэл 0.7 сая төгрөг байна. Өмнөх оноос 3.1 сая төгрөгөөр буурсан нь өмнөх онд илүү төлсөн оффисын түрээсийн авлагыг тайланд оны оффисын түрээсийн зардлыг бууруулан бүртгэсэнтэй холбоотой.
- Урьдчилж төлсөн зардал өмнөх оноос 272,752.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын суурь бүтэц барихтай холбогдсон ажлын санхүүжилтийн урьдчилгаа төлбөр 270,451.4 сая төгрөг, үйл ажиллагааны санхүүжилтийн урьдчилгаа төлбөр 2,279.5 сая төгрөг, түрээсийн барьцаа болон бусад харилцагч байгууллагуудаас үйлчилгээгээ аваагүй байгаа 21.3 сая төгрөг.
- Урьдчилгаа дансны эхний үлдэгдэлд бүртгэлтэй 2020 онд шилжүүлсэн 74,953.8 сая төгрөг байгаа нь төмөр замын суурь бүтэц барих ажлын дохиолол холбооны ажил хийгдээгүй шалтгаанаас дуусаагүй, гүйцэтгэлийг хүлээн аваагүй байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 91.3 сая төгрөгөөр өссөн нь хөдөлмөр хамгааллын хэрэгсэл 67.3 сая төгрөгийн худалдан авалттай холбоотой байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь дараах шалтгаантай байна. Үүнд: Тайлант онд шинээр худалдан авсан тээврийн хэрэгсэл 52.9 сая төгрөг, тавилга эд хогшил 69.9 сая төгрөг, компьютер техник хэрэгсэл 160.7 сая төгрөг, хэвлэх хувилах төхөөрөмж 14.2 сая төгрөг, бусад үндсэн хөрөнгө 14.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн.
- Биет бус хөрөнгө 25.9 сая төгрөгөөр өссөн нь программ хангамж, компанийн брэндбүүк болон тусгай зөвшөөрлийг шинээр бүртгэсэн байна.

- Өмчийн өөрчлөлтийн тайлан дахь нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөр өмнөх оны үр дүнг тайлант онд залруулсан 13.9 сая төгрөгийн өөрчлөлт тусгагдсан.
- Эздийн өмчийн бусад хэсэг өмнөх оноос 273,405.3 сая төгрөгөөр өссөн. Үүнд: Хувьцаа эзэмшигч “Эрдэнэс-Тавантолгой” ХК-аас төмөр замын суурь бүтэц барих төслийн санхүүжилтэд шилжүүлсэн төлбөр 270,405.3 сая төгрөг, компанийн үйл ажиллагааны санхүүжилтэд олгосон 3,000.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн.
- Хувьцааны дансны үлдэгдэл 100 ширхэг, 100.0 мянган төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 10.0 сая төгрөг байна.

Шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт зардлын хүлээн зөвшөөрөлт ба үнэлгээг “Зардлыг холбогдох орлогыг хүлээн зөвшөөрсөн тайлант үед орлоготой уялдаатайгаар хүлээн зөвшөөрнө. Харин тодорхой нэг төрлийн орлоготой шууд хамааралгүй зардлыг гарсан даруйд зардал гэж хүлээн зөвшөөрч, орлогын тайланд тусгана” гэж заасан байна.

#### **4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Тус компани Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэг хүлээхгүйн улмаас компанийн эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшинг баталдаггүй.

ТУЗ-ийн 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 09 тоот дугаар тогтоолоор “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн 2021 оны зардлын төсвийг баталсан. Үүнд үйл ажиллагааны зардалд 3,479.4 сая төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 396.1 сая төгрөг нийт 3,875.5 сая төгрөгөөр төлөвлөсөн. Уг төлөвлөгөөг “Эрдэнэс-Тавантолгой” ХК-аас хянаж элэгдлийн зардал 148.7 сая төгрөг, гадаад томилолтын зардал 45.7 сая төгрөг, спорт заалны төлбөр 9.6 сая төгрөгөөр бууруулан нийт зардлыг 3,671.5 сая төгрөгөөр үүнээс хөрөнгө оруулалтын зардалд 396.2 сая төгрөг, үйл ажиллагааны зардалд 3,275.3 сая төгрөг тус тус баталсан байна.

Тайлант онд батлагдсан зардал 3,671.5 сая төгрөгөөс гүйцэтгэлээр 2,666.6 сая төгрөгийн зардал капиталжуулсан. Үүнд үйл ажиллагааны зардалд 2,265.6 сая төгрөг, үндсэн хөрөнгө эзэмшихэд 401.0 сая төгрөг тус тус эзэлж байна.

Хэдийгээр орлогын төлөвлөгөө батлаагүй ч харилцагч байгууллагуудад гэрээний дагуу алданги тооцоноос шалтгаалан 4.1 сая төгрөгийн орлого бүрдсэн байна.

#### **5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

##### **5.1 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь тайлант онд 546,210.7 сая төгрөгийн 129 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 150.9 сая төгрөгийн 11 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна. Үүнд:

- Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгийн худалдан авалтын нийт 40 гүйлгээний 635.1 сая төгрөгөөс 5 гүйлгээний 64.2 сая төгрөгийг хугацаа хоцроосон;
- Тендэрийн мэдээллийн нийт 12 гүйлгээний 603.4 сая төгрөгөөс 4 гүйлгээний 86.6 сая төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан;
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг 5 сард хугацаа хоцроож мэдээлсэн;
- Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг бүтэн жилээр мэдээлэхдээ хугацаа хоцроосон байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасныг мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх, мэдээллийг хугацаанд нь, бүрэн мэдээлж хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмж өгөх.

## 5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт, бусад хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

## 6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 201.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 25.6 сая төгрөгийг залруулж, 155.6 сая төгрөгийн зөрчлийг арилгасан байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 75,007.0 сая төгрөгийн 3 алдаа илэрснийг санхүүгийн тайланд бүрэн залруулсан байна.

## 7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын явцад анхаарал татсан дараах асуудлуудыг дараагийн аудитаар авч үзэхээр шийдвэрлэв. Үүнд:

- Компанийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрдлөг болгох Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах ажлын хүрээнд Гүйцэтгэх захирлын 2021 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн А/82 тоот тушаалаар компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулах ажлын хэсэг байгуулагдаж “Про консалтинг плас” ХХК-тай хамтран боловсруулж дуусгаад уг төслийг компанийн ТУЗ-д танилцуулан батлуулах ажлыг гүйцэтгэж байгаа тул дараагийн аудитаар ТУЗ-өөр батлуулж, санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж ажиллаж байгаа эсэх;
- Монголын төмөр зам” ТӨХК нь төслийн хөрөнгө оруулалтын дүнд тусгагдаагүй 67,017.6 сая төгрөгийн техникийг “Зэвсэгт хүчний жанжин штаб”-д худалдан авч өгсөн байна. “Зүүнбаян төмөр зам” ХХК-д 2022 онд төмөр замын суурь бүтцийг хүлээлгэн өгөх үед уг зардлыг Засгийн газрын тогтоол гарч шийдвэрлүүлсэн эсэх;
- “Монголын төмөр зам” ТӨХК-аас 2020 оны 10 дугаар 28-ны өдөр төмөр замын суурь бүтэц барих ажлын санхүүжилтийн төсөвт өртгийг өөрчлөн 1,420.0 тэрбум төгрөг болгосныг 2021 оны 08 дугаар 04-ний өдрийн Засгийн Газрын хуралдаанаар төсөвт



өртөгт 58.4 тэрбум төгрөгийн өөрчлөлт оруулан 1,361.6 тэрбум төгрөг болгосон байна. Гэвч “Монголын төмөр зам” ТӨХК нь “Эрдэнэс Тавантолгой” ХК-руу явуулсан 2021 оны 10 дугаар 14-ний 01/1228 тоот албан бичигт санхүүжилтийн хуваарь шинэчлэгдсэн талаар тусган өөрчлөгдсөн дүнг 1.1 тэрбум төгрөгөөр дутуу мэдээлсэн байна. ТЭЗҮ-ийн өөрчлөлтийг баталгаажуулж ажиллаж байгаа эсэх;

## 8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,575.3 сая төгрөгийн алдаа илэрснээс 2,280.9 сая төгрөгийн алдааг залруулж, 274.4 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 20.0 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 294.4 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 18.3 сая төгрөгийн материаллагийн түвшнээс 276.1 сая төгрөгөөс Их байгаа тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

### 8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 2,280.9 сая төгрөгийн 3 алдааг залрууллаа. Үүнд:

- ТЭЗҮ-ийн дагуу төслийн өртөгт багтсан үйл ажиллагааны санхүүжилтээр гарсан зардлыг тайлант оны зардлаар бүртгэсэн 2,265.6 сая төгрөгийг урьдчилж гарсан зардал, тооцоо дансанд залруулан бүртгэв.
- Өмнөх үеийн хуримтлагдсан үр дүн 14.0 сая төгрөгийг урьдчилж гарсан зардал, тооцоо дансанд залруулан бүртгэв.
- Орлогын албан татварын зардлыг 1.3 сая төгрөгөөр залруулан бүртгэв. т

### 8.2 Албан шаардлага

Зүүнбаян төмөр зам ХХК болон “Монголын төмөр зам” ТӨХК-ийн хооронд байгуулсан төмөр замын төслийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн гэрээгээр санхүүжилтийн зарцуулалтын талаар тайлагнаж, холбогдох мэдээллийг ирүүлэхтэй холбоотой харилцаа эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлсон. Уг гэрээний дагуу санхүүжилтийн төлбөр шилжүүлэх тухай бүр өмнөх санхүүжилтийн тайлан болон ажил гүйлгээний төлбөрийн даалгаврыг гаргуулан авсан хэдий ч гүйцэтгэлийн дүнг хянан баталгаажуулахгүй байна. Тус компани үүсгэн байгуулагдсанаас хойшхи “Монголын төмөр зам” ТӨХК руу төмөр замын төслийн санхүүжилтэд 7 удаагийн гүйлгээгээр нийт 345,405.3 сая төгрөг шилжүүлснийг Монголын төмөр зам ТӨХК-аас ирүүлсэн гүйцэтгэлийн тайлан мэдээтэй тулган шалгахад 345,679.7 сая төгрөг буюу 274.4 сая төгрөгөөр илүү гүйцэтгэлтэй байна. Гэрээнд заасны дагуу ажлын гүйцэтгэлийг хянаж баталгаажуулаагүй байна.

Энэ нь “Санхүүжилтийн гэрээ” 3 дугаар зүйлийн 3.1 “Зүүнбаян төмөр зам ХХК нь дараах нөхцөл хангагдсаны дараа энэхүү гэрээнд заасан санхүүжилтийг Монголын төмөр зам ТӨХК-ийн дансанд шилжүүлнэ”, 3.1.2-т “Энэхүү гэрээнд заасан үнийн дүн бүхий санхүүжилтийг Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын суурь бүтэц барих шаардлагатай санхүүжилтийн баталгаажсан гүйцэтгэлийн дүнгээс шилжүүлэх төлбөрийн задаргааг /ажил, гэрээ тус бүрээр/; Монголын төмөр зам” ТӨХК-аас ирүүлсэн; 4.2. “Энэхүү гэрээний дагуу хүлээн авсан санхүүжилтийг талуудын хянан баталгаажсан актад заасан дүнгээр төмөр замын төслийн гүйцэтгэлд зориулна” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

### 8.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

Тайлант онд харьцуулалтын арга хэрэглээгүй “Хангайн сонор” ХХК болон “Тод мэдээ грөү” ХХК-аас 20.0 сая төгрөгийн ажил үйлчилгээг шууд худалдан авалт хийсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33.2.1 “*үнийн санал ирүүлэх урилгыг энэ хуулийн 52.1.12, 53.5.4-т заасан худалдан авах ажиллагааны цахим системд зарлаж, үр дүнг тухай бүр мэдээлэх*”, 33.2.2 “*техникийн болон бусад нөхцөл шаардлагыг хангаж байгаа хамгийн бага үнэ санал болгосон тендэрт оролцогчид энэ хуулийн 29.1-д заасны дагуу гэрээ байгуулах эрх олгох*” 8 дугаар зүйлийн 8.1.2. “*шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар*”; ЗГ-ын “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 2021 оны 124 дугаар тогтоолын хавсралтын холбогдох заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан худалдан авах журмын дагуу худалдан авалтыг зохион байгуулж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах нь зүйтэй.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Санхүүгийн тайлангийн асуудлаар</b>																
1	Зүүнбаян Төмөр Зам ХХК	АХГ-2022/73/НА-СТА-ТӨА	ТЭЗҮ-ийн дагуу төслийн өртөгт багтсан компанийн үйл ажиллагаанд зарцуулагдсан зардлыг ангилал залруулан бүртгэв.	Санхүүгийн тайланд залруулга хийх	1	2,265,564.4	1	2,265,564.4								
2	Зүүнбаян Төмөр Зам ХХК	АХГ-2022/73/НА-СТА-ТӨА	Өмнөх үеийн хуримтлагдсан үр дүнг залруулав	Санхүүгийн тайланд залруулга хийх	1	13,982.7	1	13,982.7								
3	Зүүнбаян Төмөр Зам ХХК	АХГ-2022/73/НА-СТА-ТӨА	Орлогын албан татварын зардлыг залруулав	Санхүүгийн тайланд залруулга хийх	1	1,393.8	1	1,393.8								
4	Зүүнбаян Төмөр Зам ХХК	АХГ-2022/73/НА-СТА-ТӨА	Харьцуулалтын арга хэрэглэхгүйгээр “Хангайн сонор” ХХК болон “Тод мэдээ грөү” ХХК-аас 20.0 сая төгрөгийн ажил үйлчилгээг шууд худалдан авалт хийсэн.	Худалдан авах журмын дагуу худалдан авалтыг зохион байгуулах	1	20,000.0								1	20,000.0	
5	Зүүнбаян Төмөр Зам ХХК	АХГ-2022/73/НА-СТА-ТӨА	Төслийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн гэрээнд заасан үүрэг биелэгдээгүй.	Гэрээний үүргийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага	1	274,394.7					1	274,394.7				
<b>ДҮН</b>					<b>3</b>	<b>2,575,335.6</b>	<b>3</b>	<b>2,280,940.9</b>			<b>1</b>	<b>274,394.7</b>		<b>1</b>	<b>20,000.0</b>	
<b>Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал</b>																
1	Зүүнбаян Төмөр Зам ХХК	АХГ-2022/73/НА-СТА-ТӨА	2021 оны нийт 133 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд ил тод байршуулахаас 3 мэдээллийг ил тод байршуулаагүй, зарим мэдээллүүдийг хугацаа хоцроон байршуулсан байна.	Мэдээллийг хугацаанд нь, бүрэн мэдээлж хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах	1	150,989.8								1	150,989.8	
<b>ДҮН</b>					<b>1</b>	<b>150,989.8</b>								<b>1</b>	<b>150,989.8</b>	
<b>НИЙТ ДҮН</b>					<b>6</b>	<b>2,726,325.4</b>	<b>3</b>	<b>2,280,940.9</b>			<b>1</b>	<b>274,394.7</b>		<b>2</b>	<b>170,989.8</b>	



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 606/А0150053  
АХГ-2022/43/НН-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Зүүнбаян төмөр зам ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Зүүнбаян төмөр зам ХХК болон Монголын төмөр зам ТӨХК-ийн хооронд байгуулсан төмөр замын төслийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн гэрээгээр санхүүжилтийн зарцуулалтын талаар тайлагнаж, холбогдох мэдээллийг ирүүлэхтэй холбоотой харилцаа эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлсон. Уг гэрээний дагуу санхүүжилтийн төлбөр шилжүүлэх тухай бүр өмнөх санхүүжилтийн тайлан болон ажил, гүйлгээний төлбөрийн даалгаврыг гаргуулан авсан хэдий ч гүйцэтгэлийн дүнг хянан баталгаажуулахгүй байна. Тус компани үүсгэн байгуулагдсанаас хойш Монголын төмөр зам ТӨХК руу төмөр замын төслийн санхүүжилтэд 7 удаагийн гүйлгээгээр нийт 345,405.3 сая төгрөг шилжүүлснийг Монголын төмөр зам ТӨХК-аас ирүүлсэн гүйцэтгэлийн тайлан, мэдээтэй тулган шалгахад 345,679.7 сая төгрөг буюу 274.4 сая төгрөгөөр илүү гүйцэтгэлтэй байна.

Энэ нь “Санхүүжилтийн гэрээ”-ний 3 дугаар зүйлийн 3.1 “Зүүнбаян төмөр зам ХХК нь дараах нөхцөл хангагдсаны дараа энэхүү гэрээнд заасан санхүүжилтийг Монголын төмөр зам ТӨХК-ийн дансанд шилжүүлнэ”, 3.1.2 “Энэхүү гэрээнд заасан үнийн дүн бүхий санхүүжилтийг Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын суурь бүтэц барих шаардлагатай санхүүжилтийн баталгаажсан гүйцэтгэлийн дүнгээс шилжүүлэх төлбөрийн задаргааг /ажил, гэрээ тус бүрээр/”, 4.2. “Энэхүү гэрээний дагуу хүлээн авсан санхүүжилтийг талуудын хянан баталгаажсан актад заасан дүнгээр төмөр замын төслийн гүйцэтгэлд зориулна” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, даван гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө” Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Санхүүжилтийн гэрээнд заасан үүргийг биелүүлж, гүйцэтгэлийг баталгаажуулж ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зүүнбаян төмөр зам ХХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Банзрагч, ерөнхий нягтлан бодогч Н.Цэрэнбанзад нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР



Д.ЭНХДАЛАЙ

ГРОУТ ФИНАНС АУДИТ ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.БЯМБА

